Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН ХҮНС, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАНМЭРГЭЖИЛТЭН ЦОГТООГИЙН ЭРДЭНЭЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх, хэрэглэгчдэд нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, тайлагнах | Бэлтгэсэн мах тн-оор | 20 тн | 20тн | Хүн амын хаврын хэрэгцээний махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөргөдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор 2024 онд орон нутгийн төсвөөс 145.6 сая төгрөгийн санхүүжилтээр 20 тн хонины мах бэлтгэн 13 багийн 13 хүнсний дэлгүүрээр худалдаанд гаргаж иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн байна. 2025 оны нөөцийн махны тендер зарлагдаж Итгэлт хүнс баялаг хязгаарлагдмал хариуцлагтай компани шалгарч 146,5 сая төгрөгөөр 18 тн хонины мах нийлүүлэх гэрээ байгуулсан байна. | 2024.01.01 2024.12.15 | 100 |
| 2. | Орон нутагт хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төсөвт байгууллага, иргэн, аж ахуйн | Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн иргэн, аж ахуй нэгжийн тоо | 15 | 15 20 | “Хүнсний аюулгүй байдал” 3 сарын аяны хүрээнд хүнсний худалдаа эрхлэгч, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч, хоол үйлдвэрлэл эрхлэгч 75 иргэн аж ахуй нэгж, хоол үйлдвэрлэл үйлчилгээ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгжүүдэд хүнсний аюулгүй байдал, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний салбарт шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, стандарт, журам, тогтоол, шийдвэрүүдийг сурталчлах, тэдгээрийг мөрдүүлж, хэрэгжилтийг хангуулах талаар улирал бүр шалган туслах арга хэмжээ болон сургалт, хэлэлцүүлэг, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулан, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөгөөр хангаж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, хамтран ажилласан байх | | | | эрхлэгчдийн 28 төлөөлөлд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, хүнсний тухай хууль болон шинэчлэгдсэн стандартын талаарх мэдээлэл, зөвлөмж өгөх зорилгоор танхимын сургалт, үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| | | Хяналт шалгалт хийсэн аж ахуй нэгжийн тоо | 10 | 15 | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн 75 аж ахуй нэгжийн хүсэлтийг холбогдох материалтай хүлээн авч хүсэлтийн дагуу хяналтын албаны улсын байцаагч нартай хамтран хяналт шалгалтыг хийж дүгнэлт гаргуулан ажиллаа. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн орчимд хүнсний аюулгүй байдлыг хангуулах хяналт тавих зорилгоор 7 хүнсний дэлгүүрт хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллаа. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| | | Арилгуулсан зөрчлийн хувиар | 2 | Илэрсэн зөрчлийн хувиар | Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар явцын зөрчил дутагдал арилгуулах улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг 38 аж ахуй нэгжид хүргүүлж зөрчлийг арилгуулан ажилласан байна. | 2024.01.01<br>2023.12.15 | 100 |
| 3. | Сургуулийн үдийн хоол, дотуур байр, цэцэрлэгийн хоолны түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлын талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн тоогоор | 1 | 2 | Мал эмнэлгийн тархвар зүйч эмчтэй хамтран Ерөнхий боловсролын 2,4 мэргэд сургууль, үдийн хоолны түүхий нд бүтээгдэхүүнээс дээж авч дээжид шинжилгээ хийхэд хүнсний хэрэгцээ шаардлага хангахгүй муудсан болон антибиотикийн үлдэгдэлтэй, исгэлэн хэвийн хэмжээнээс их бүтээгдэхүүн илрээгүй. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдааны цэг, салбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нэгтгэн авч, тухай бүр үнэн зөв бодитой мэдээлж, хангамж, нийлүүлэлтийн тэнцлийг үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн улирал тутам бодитой тооцож ажилласан байх | Хүнсний бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тэнцэл тооцож ажилласан эсэх | Нөөцийн мэдээ 24 Хүнсний тэнцэлийн мэдээ 2 | Нөөцийн мэдээ 24 Хүнсний тэнцэлийн мэдээ 2 | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 58 томоохон хүнсний дэлгүүр, хүнсний бөөний төвүүдээс 7 хоног бүрийн баасан гаригт хүнсний нөөцийн мэдээг авч нийт 46 удаагийн мэдээг Даваа гариг болгон Хүнс, хөдөө аж ахуйн яамны foodsupply.mofa.gov.mn программид оруулан ажиллаж байна.<br>Мөн хүнсний хангамж, нийлүүлэлтийн тэнцлиийг үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн хагас, бүтэн жилийн байдлаар гарган аймгийн ХХААГазарт хүргүүлэн ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| 5. | Хүнсний зориулалтын бус савыг хүнсний зориулалтаар ашиглах байдлыг шат дараалалтай бууруулах, зориулалтын саваар солих нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 1 | 1 | Занабазар цэцэрлэгт хүрээлэнгийн баруун талд "Өглөөний гудамж" худалдаа үйлчилгээний гудамжийг шинээр байгуулж, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 17,4 сая төгрөгөөр 12 ширхэг асар байршуулан малчдын гар дээрээс тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй органик, эрүүл аюулгүй сүү цагаан идээ, олон нутгийн тариаланчдаас төмс, хүнсний ногоо, хүнс үйлвэрлэгчдийн талх нарийн боов зэрэг өдөр тутмын хүнсний хэрэглээний бүтээгдэхүүний худалдан авах бодомжийг бүрдүүлэх зорилгоор худалдааны гудамжийг нээсэн. Мөн МЭГ-ийн лабораторийн мэргэжилтэн тус худалдааны гудамжинд зарагдаж байгаа сүү цагаан идээнд тогтмол шинжилгээ хийж, зориулалтын саванд хийж хадгалах, савлах, борлуулах шаардлага тавьж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төвлөрсөн цэгт ангилан ялгах хогийн сав байрлуулан, 7 хоног бүрийн Лхагва гарагт тогтмол хогийг ачуулж, хяналт тавин ажиллаж байна. | | |
| | | Зориулалтын бус савыг зориулалтын саваар сольсон айл өрх, албан байгууллагын тоо | 80 | 100-аас доошгүй | Харъяа төсөвт 14 цэцэрлэг, 5 сургуулийн гал тогоо үйл ажиллагаандаа 100 хувь хүнсний зориулалтын сав хэрэглэж хэвшсэн байна. Хүнсний зориулалтын бус хуванцар савны хор уршгийг сурталчлан ойлгуулж, хуванцар савнаас татгалзах сэдэл, хандлагыг төлөвшүүлэх зорилготой 3 удаагийн сургалт хийж 1500 гаруй өрх хуванцар савнаас татгалзаж, хүнсний зориулалтын хуванцар савыг өдөр тутмын хэрэглээндээ хэрэглэж хэвшээд байна. | 2024.01.01 2024.12.15 | 100 |
| 6. | Хүнсний чиглэлийн бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор нэн тэргүүнд дэмжиж ажиллах (ЖДҮХС, ХХС, бусад төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр) | Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо, санхүүжилтийн хэмжээ | 10 иргэнд 138 сая төгрөг | 70-с доошгүй | Хоршоо хөгжүүлэх сангаас сүү цагаан идээ боловсруулах, үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Амжилтын сүүн зам хоршоо 100 сая, Ааруул дээж ХХК 25 сая, төмс хүнсний ногоо боловсруулах чиглэлээр Арвин шунхлай хоршоо 85 сая төгрөгийн зээлд хамрагдсан. | 2024.01.01 2024.12.10 | 100 |
| 7. | "Намрын ногоон өдрүүд - 2022" улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээний хүрээнд сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, бүс, аймгийн үзэсгэлэн худалдаанд | Оролцогчдын тоо | - | 80-с | Өвөрхангай түншлэл-Алтан намар 2024" үзэсгэлэн худалдаанд 18 гаруй иргэн, аж ахуйн нэгж хүч хөдөлмөрөө шингээсэн органик төмс, хүнсний ногоо, даршилсан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, төрөл бүрийн цай, эмийн ургамал, оёдол, гар урлал, модон, арьс, ширэн эдлэл зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээр | 2024.01.01 2024.12.10 | 100 |

191

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцуулахад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах | | | | оролцлоо. | | |
| | | Борлуулалтын хэмжээ | 18 сая | - | “Өвөрхангай түншлэл-Алтан намар 2024” үзэсгэлэн худалдаанд 18 иргэн аж ахуй нэгжүүд оролцож 19,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | 2024.01.01 2024.12.15 | 100 |
| **Зорилт 2. “Жижиг, дунд хөнгөн үйлдвэр хоршооны салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж төсөл, хөтөлбөрийг иргэн, аж ахуй нэгжид сурталчлах, мэдээллээр хангах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн /өлөн гэдэс, яс, эвэр, туурай, өөх, тос, сэвс/ боловсруулах кластер хэлбэрийн үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх | Үйлдвэр, цехэд дэмжлэг үзүүлсэн тоогоор | 1 аж ахуй нэгжид 40 сая | - | Малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүны үйлдвэрлэлээ өргөжүүлэх, бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж сайжруулах зорилгоор Түмний буян далай хоршоо нь Хоршоо хөгжүүлэх сангаас 100 сая төгрөгмийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | 2024.01.01 2024.12.15 | 100 |
| 2. | Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг хэвлэл, мэдээлэл, цахим орчинд сурталчлан таниулж, “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төвөөр худалдаалах боломжийг бүрдүүлж, борлуулалтын дүнг гаргаж тайлагнах | Борлуулалтын хэмжээ /сая. төг/ | 70 сая | 30 сая | Өвөрхангайд үйлдвэрлэв” төвөөр 52 аж ахуй нэгж, 116 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийн сүү сүүн бүтээгдэхүүн, арьс, шир, суран эдлэл, модон эдлэл, сийлбэр, эсгий, ноосон эдлэл зэрэг 19 нэр төрлийн 700 гаруй бараа бүтээгдэхүүнийг борлуулж 59,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Онлайн худалдааны info@uvurkhangaishop.mn сайтаар дамжуулан бараа, бүтээгдэхүүний захиалга авч, 2.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | 2024.01.01 2024.12.15 | 100 |
| 3. | “Өглөөний гудамж”-ны үйл ажиллагааг тогтмолжуулж, худалдаа эрхлэгчийн худалдаалж байгаа бүтээгдэхүүний төрлийг нэмэх, өргөжүүлэхэд анхаарч ажилллах | Худалдаа эрхлэгчдийн тоогоор | 15 малчин өрх | - | Занабазар цэцэрлэгт хүрээлэнгийн хатуу хучилттай зогсоолд Өглөөний гудамж буюу малчдын гар дээрээс тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй органик, эрүүл аюулгүй сүү цагаан идээ, олон нутгийн тариаланчдаас төмс, хүнсний ногоо, хүнс үйлвэрлэгчдийн талх нарийн боов | 2024.01.01 2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зэрэг өдөр тутмын хүнсний хэрэглээний бүтээгдэхүүний худалдан авах бодомжийг бүрдүүлэх зорилгоор худалдааны гудамжийг нээсэн. Худалдааны гудамжаар өдөрт 15-18 малчин тогтмол худалдаа эрхэлж Мөн МЭГ-ийн лабораторийн мэргэжилтэн тус худалдааны гудамжинд зарагдаж байгаа сүү цагаан идээнд тогтмол шинжилгээ хийж, зориулалтын саванд хийж хадгалах, савлах, борлуулах шаардлага тавьж ажилласан. Төвлөрсөн цэгт ангилан ялгах хогийн сав байрлуулан, 7 хоног бүрийн Лхагва гарагт тогтмол хогийг ачуулж, хяналт тавин ажиллаж байна. | | |
| **Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1 | Жилийн ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлуулан дүгнүүлэх | Хэрэгжилтийн хувь | - | Байгууллага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан тайлагнаж ажилласан байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, сумын Засаг даргатай байгуулсан аймгийн Засаг даргын гэрээний биелэлт, үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн биелэлт зэрэг бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтын тайланг хугацаанд нь гаргаж өгч хэвшсэн | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| 2 | “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх сумын нэгдсэн төлөвлөгөө батлуулан дүгнүүлэх | Хэрэгжилтийн хувь | | Төлөвлөгөөг боловсруулж тайлагнасан байна 100 | “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” 5 жилийн төлөвлөгөөг боловсруулан, сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын 17/02 дугаар тогтоолоор батлуулж 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг ИТХурлын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хүнс, жижиг дунд үйлдвэрийн салбартай холбоотой мэдээ, мэдээлэл, судалгааг боловсруулах, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээ мэдээллийг холбогдох байгууллага, нэгж албан тушаалтанд хүргүүлэх | Аж үйлдвэрийн мэдээ-12 | 12 | 12 | Сар бүрийн 25-ны дотор жижиг дунд үйлдвэр эрхлэгч 21 иргэнээс аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сар бүрийн мэдээг авч нэгтгэн сумын статистик хариуцсан мэргэжилтэнээр дамжуулан аймгийн статистикийн газарт маягтаар болон цахим хэлбэрээр хүргүүлэв. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| | | Хууль, тогтоолын хэрэгжилтийн хувь | - | Сурталчилан ажилласан иргэн, аж ахуй нэгжийн тоо | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хоршооны тухай хууль, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг жижиг дунд үйлдвэрийн газрын зээл, төсөл хөтөлбөртэй холбоотой холбогдох журам, удирдамж, Засгийн газрын 157 дугаар журам, хоршоог хөгжүүлэх сангийн зээл олгох журам, аймаг сумын зорилтот жил зэргийг давхардсан тоогоор 270 гаруй иргэн, аж ахуйн нэгжид сурталчилан, мэдээ, мэдээллээр хангаж ажилаллаа. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| | | Шаардлагатай тоо баримт, мэдээ мэдээллийг холбогдох байгууллага, нэгж албан тушаалтанд хугацаанд нь хүргэсэн эсэх | | Шаардлагатай, тоо, баримт мэдээг цуглуулж хугацаандаа мэдээлсэн байна. | Бүх төрлийн судалгаа тайлан мэдээллийг цаг хугацаанд нь, үндэслэлтэй, үнэн бодот байдалд тулгуурлан, үр дүнг тооцон боловсруулж дүн шинжилгээ хийж ажиллсан. Сумын хэмжээнд Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 108 иргэн аж ахуй нэгжийн хүнсний дэлгүүрийн судалгааг гаргаж аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. Тамхи худалдаалах тусгай | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрөлтэй 113 иргэн аж ахуй нэгжүүдийн хүнсний дэлгүүрийн судалгааг гарган аймгийн МХГазарт хүргүүлэн байна. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн иргэн аж ахуй нэгжүүдийн хүсэлтийн дагуу Аймгийн МХГазартай хамтран 5 удаагийн төлөвлөгөөт бус шалгалтыг хийж 73 хүнсний дэлгүүрт тусгай зөвшөөрлийг олгуулахаар аймгийн ХЭЗХэлтэст уламжлан олгосон. | | |
| 5 | Тамхи худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн иргэн аж, ахуй нэгжүүдийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж зөвшөөрөл олгож шийдвэрлэх | Хүсэлт олгосон тоогоор | | шийдвэрлэлт 100 хувь | 2024 оны жилийн эцсийн байдлаар ЗДТГазарт тамхи худалдан борлуулах хүсэлт ирүүлсэн 11 иргэн аж ахуй нэгжээс 10 тусгай зөвшөөрлийг олгосон. 1 иргэний хүсэлт Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалт буюу “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдаалахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчихөөр байгаа тул иргэнд албан тоот, утасаар тусгай зөвшөөрөл олгох боломжгүй хариуг мэдэгдсэн. | 2024.01.01 2024.12.15 | 100 |
| 6 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг | Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь | | 100 хувь | Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл хүссэн 9 иргэн, аж ахуй нэгжээс өргөдөл хүлээн авч 3 өргөдлийг журамын дагуу шийдвэрлэсэн байна. 3 иргэний хүсэлт шийдвэрлэгдэх боломжгүй байгааг тул иргэнд хариуг утасаар болон албан тоотоор мэдэгдсэн. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн 53 иргэний | 2024.01.01 2024.12.15 | 100 |

195

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сонирхлыг зохицуулах | | | | өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч аймгийн мэргэжлийн хяналтын газартай хамтарсан хяналт шалгалт хийж тусгай зөвшөөрөл олгуулахаар аймгийн Хууль эрх зүйн хэлтэст уламжилсан байна. | | |
| | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэх гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан эсэх | | Зөрчил гаргалгүй ажилласан байна. | Шалтгаангүйгээр ажил таслах, хоцрох, ажлын байранд болон ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчил гаргалгүй мөн сахилгын шийтгэлгүй, харилцаа хандлагын талаар гомдол гаргалгүй ёс зүйн дүрмийг баримтлан ажилласан. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | АЗ сургалтад хамрагдах | | - | Танхимаар болон онлайн хэлбэрээр сургалтад хамрагдсан байна. | Сургалтад хамрагдсан боловч шалгалтанд тэнцээгүй . | 2024.01.01<br>2024.12.15 | 70 |
| 2. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах сертефикаттай сургалтад хамрагдах | | - | Танхимаар болон онлайн хэлбэрээр сургалтад хамрагдсан байна. | Пүрэв гариг бүр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг цуврал сургалтад 5 удаа хамрагдсан. | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |
| 3. | Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчдад зориулсан цуврал сургалтуудад хамрагдах | | - | Танхимаар болон онлайн хэлбэрээр сургалтад хамрагдсан байна. | ХХААХҮЯам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, хөдөө аж ахуйн бирж зэрэг газруудын ажил мэргэжлийн холбоотой сургалтуудад давхардсан тоогоор 6 удаа хамрагдаад байна.<br>Хөгжлийн шийдэл ТББ-ын Хүнсний | 2024.01.01<br>2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулах үйлдвэрүүдийн дотоод ауидит хийх танхимын болох үзүүлэх сургалтанд сууж сертефикат авсан. | | |
| 4. | Монгол бичгийн ахисан түвшний сургалтад хамрагдах | | - | Танхимаар болон онлайн хэлбэрээр сургалтад хамрагдсан байна. | Монгол бичгийн унших, зөв бичих чадвараа ахиулж бие даан суралцаж байна. | 2024.01.01<br>2024.12.15 | 70 |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ЭРДЭНЭЖАРГАЛ

2024 оны 11 дүгээр сарын 22

197